



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Г Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сантланс ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон Хорооны 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 36 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг чанд биелүүлж ажиллахыг үүрэг болгож, цаашид зөрчил давтан гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхийг “Сантланс ХААБ” ХХК-ийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН